



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/525

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 66.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2022 оны 78 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 34 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэж буй Багш, оюутан, сурагч удирдах ажилтныг чадавхжуулах, шинэ технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ танилцуулах арга хэмжээний зардалд шаардагдах 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан эх үүсвэрээс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат) -т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

